



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/936

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам-ын 2.1.4, 2.1.5 дахь дэд заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 88 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Налайх дүүргийн нийтийн зориулалттай гурван орон сууц хур бороо ихээр орсны улмаас дээврээсээ усанд автаж гамшиг ослын нөхцөл байдалд хүрсэн тул дээврийн засварын ажлыг холбогдох хууль журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулж ажиллахыг Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазарт үүрэг болгосугай.

2.Энэ захирамжийн 1-д заасан дээврийн засварын ажлын санхүүжилтэд шаардагдах 100,000,000.00 (нэг зуун сая) төгрөгийг Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т, гүйцэтгэлээр санхүүжилтийн эрх нээж, санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Эрдэнэбадрах)-т тус тус зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Эрх шилжүүлэх тухай” Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/834 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР